

ЭЗЭН ХОРОО

С.Д.ДЫЛЫКОВ

1956 оны хавар миний бие БНХАУ-д зорчих үеэр Ордос дахь (ӨМӨЗО-ы Их-Зуу аймаг) Эзэн Хороо хэмээх газар очиж Чингис хааны онгон шүтээнийг үзэх завшаан тохиосон юм.

Хятад, Японы дайны үеэр Чингис хааны онгоныг Хөх нуурын Гумбун хийдэд шилжүүлэн залж байгаад 1954 онд Өвөр Монголын тусгай элч төлөөлөгчид Эзэн Хороонд буцаан авчирчээ.

Монголчуудын уламжлалаар энд жил бүрийн билгийн тооллын 3-р сарын 21-нд (4-р сарын дунд үе) Чингис хааны сүнс, сүлдний их тайлгын ёслолыг үйлддэг байна. Дашрамд энэ цаг хугацаа нь Монголын хааны мэндэлсэн ч юмуу таалал төгссөн сар өдрийн алинтай нь ч дүйцдэггүй юм билээ. Энэ үеэр Өвөр Монголын өнцөг булан бүрээс маш олон хүн хуран цуглаж, хэдэн өдөр үргэлжилсэн ёс үйлддэг аж. Чингээд бас ч үгүй хүйтэн сэрүүн цаг тул олон ард зам зуурт Хатан голыг завь онгоцоор гатлахаас өгсүүлээд Эзэн Хорооноо хүрсэн хойноо ч тух алдаж ихэд зүдэрдэг байсны учир Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ардын Хороо, нутаг нутгийн түмэн олны хүсэл ээрэлд нийлүүлэн 1956 онд Чингис хааны тахил тайлгын өдрийг цагаан идээ дэлгэрэн элбэгшдэгийг бэлэгтэй сайн өдөр гэж билгийн тооллын 5-р сарын 15 (аргын тооллогын 6-р сарын 15)-аар товлон тогтоожээ. Чухам жилийн энэ өдөр Чингис хааны үед ч унага барьж, үрс гаргах ёс үйлддэг байсан тухай ам мэдээ буй. Ордос нутагт урин дулаан болж мал төл, газар тариалангийн ажлаа нугалж, амарсан ард олон зоо тэнийдэг энэ л үеийг сонгосон нь учиртай аж. Би бээр 1956 оны 4-р сарын 8-ны өглөө Их-Зуу аймгийн Ардын Хорооны орлогч дарга Ма Фунган болон бусад нөхдийн хамт аймгийн төв болох Дуншэн хотоос Эзэн Хороонд ирсэн юм. Эзэн Хорооны чухал дурсгалууд, гол нь Чингис хааны онгон, тэнд хадгалагдаж буй эртний гар бичмэлүүдийг үзэж танилцах боломжийг надад олгох зорилгоор, биднийг ирэхээс өмнө өөр нэг орлогч дарга Цзин Ханвэнь наашаа ирж, Чингис хааны онгон шүтээнийг хамгаалагч дархадуудтай хамт бэлтгэл ажил хийв. Учир нь Чингис хааны их тайлгын өдрүүдэд л онгон шүтээнийг нээдэг агаад гар бичмэлүүдийг машид нуудалдаг байна. Гэхдээ Цзин Ханвэний ачаар дархадууд өөрийн догшин өвөг дээдсийн онгон шүтээнийг нээгээд зогсохгүй түүнд холбогдох эд зүйлсийг надад үзүүлэхээр болсон билээ.

Бунхан нь ойролцоогоор 2 куб.м орчим хэмжээтэй, мөнгөн ялтсаар эмжсэн уран сийлбэртэй модон авдар байлаа. Түүнийг эртний монгол гэрт өндөр модон суурь дээр байрлуулжээ. Авдран дотор бас нэг жижиг авдар байх бөгөөд дархадуудын яриагаар бол Чингис хааны

чандрыг дотор нь хийсэн юм байна. 1910 онд профессор Ц.Ж.Жамцараног Эзэн Хороонд ирж үзэхэд авдарт Чингис хааны үсний үлдэгдлийг жижигхэн жинтүүнд хийж тавьсан байсан гэх ба “Чингис хааныг газар шороонд оршуулсан болохоор түүнээс үлдэж уламжлагдсан шарил чандар зүйл байх учиргүй”¹ гэжээ. Авдрын дээд талд янз бүрийн бөс даавууны өөдөс тавьж дээр нь гар бичмэл гурван ном, торгон хуйлмал бичиг, Чингис хааны гэр бүлийн хөрөг бололтой зурагт түүнийг хатадынх нь нэгэнтэй, дүү нар болон хөвгүүдийг хатадтай нь хамт дүрслэн өнгийн утсаар хатган шаглажээ. Энэ зургийг Чингис хааны үеэс нандигнан хадгалж ирсэн, гэрээс огт гаргаагүй гэдгийг дархадууд баталж, бидэнд байгаа газраас нь гэрэл зураг авахыг зөвшөөрөв.

Дархадууд гар бичмэлийг миний байгаа буудалд орой авчирч өгөөд маргааш өглөө нь буцааж авахаар болов. Ийнхүү би нэг шөнийн дотор тэдгээрийг зөвхөн уншаад зогсохгүй хуулж бичих боломжтой болсон юм.

Эхний ном шар торгон хавтастай, 28x15,5 см хэмжээний, 10 хуудас бүхий. Эртний монгол хэлээр 15 нүүрийг, хар дэвсгэр хийж, бөс эдээр эмжсэн, зузаан хөх хятад цаасан дээр алтаар бичсэн байна. Энэ номыг дархадуудын нэрлэж буйгаар “Алтан дэвтэр” гэх агаад, жил бүр билгийн тооллын 3-р сарын 20-нд Чингис хааны их тайлгын үеэр “түлш түлэх” зан үйлийн ёслолд уншдаг, маш их элэгдсэн боловч сайн хадгалагдсан байна. Уг ном Чингис хаан түүний хатад, хөвгүүд болон үр удмынханыг дээдлэн шүтсэн мөргөлийн утгатай эртний монголоор бичсэн ном аж.

Хоёрдугаар ном мөн л шар торгон хавтастай, 25x11,5 см, 13 хуудастай. Уг бичгийг эртний монгол хэлээр 22 нүүр, хар дэвсгэртэй, хөх өнгийн зузаан, хятадын хатуу цаасан дээр алтаар бичсэн байна. Гар бичмэл маш их элэгдэж, олон хуудас урагдаж цавуугаар наасан, бичгийг зарим газар хар бэхээр сэргээсэн болохоор уншихад маш хүндрэлтэй байв. 16-р хуудсанд номын нэрийг “Алтан бичиг” гэжээ.

Чингис хааныг тухайлан судалсан хүний хувьд Ц.Ж.Жамцарано, хэдийгээр мөн “Алтан дэвтэр”² гэсэн нэртэй боловч энэ л номыг ашиглаж байсан бололтой. Гэхдээ Эзэн Хороон тухай тайлагнан бичихдээ “түлш түлэх” үед голдуу уншдаг байсан хоёрдахь номын тухай дээрхи нэрээр нь ч дурьдсан зүйлгүй байдаг.

Тэнгэр-тэнгэрт залрагсад, уул усны онгон савдагийг шүтэх эртний монгол бөөгийн уншлага дуудлагатай “Алтан бичиг”-ийг билгийн тооллын 3-р сарын 21-нд “их тайлгын” өдөр жил бүр уншдаг заншилтай бөлгөө. Энэ номыг эхний номын нэгэн адил би өөрөө эх бичгээс бүгдийг нь хуулж авсан болно.

Гуравдугаар ном хавтасгүй, 17х13 см хэмжээтэй, 40 хуудастай, монголоор нүүрэн болон ар талд нь хар бэхээр хятадын цагаан цаасан дээр бичиж нугалбарласан. Гар бичмэл маш их элэгдсэн, олон хуудас үнгэгдсэн боловч бичиг нь тод харагдаж буй нь харьцангуй саяхны хуулбар бололтой. Энэ номыг мөн “их тайлгын” өдөр уншдаг. Дархадуд хэлэхдээ, энэ номонд Чингис хааны намтрыг бичсэн гэх боловч нарийн үзвэл номын эхний хэсэгт Чингис хааны алдар сүрийг магтсан, эрхэм найруулгатай, шүлэглэж бичсэн магтаал, харин хоёрдугаар хэсэгт тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа арвин ихээр өсч бойжин, монголчуудад хэмжээлшгүй буянаа хайрлах болтугай гэсэн билэгдлийн ерөөл байв. Цаг бага учраас би уг номыг бүрэн хуулж чадаагүй. Энд би магтаалын зарим шүлгийн бадгаас дээж болгон эртний монголын яруу найргийг хуулж авчирсан юм. Эзэн Хороонд эдгээр гар бичмэлээс гадна Чингис хааны бунханд монголын ард түмний түүх, соёлд холбоотой өөр ямар ч бичгийг би олж хараагүй.

Академик Б.Я.Владимирцов Эзэн Хорооны дурсгалт газрыг ихэд сонирхож байсан. Борис Яковлевич өөрийн суурь судалгаа болох “Чингис хаан”, “Монголчуудын нийгмийн байгуулал” зэрэг бүтээлдээ Ц.Ж.Жамцараногийн тухайн үед Эзэн Хорооноос авчирсан судлагдахууныг өргөн ашигласан байна. Тэр үед Б.Я.Владимирцов эдгээр судлагдахууныг хэрэглэхдээ “гэдгээрийн үүсэл гарал зарим нэг эргэлзээ төрүүлж байгаа учраас ихэд болгоомжтой” хандахыг зөвлөж,³ XIX зууны 70-аад оны үед Эзэн Хорооны эд зүйл, эрдэнэс тоногдон, үнэтэй ховор гар бичмэлүүд шатаагдсан⁴ хэмээжээ.

1956 он хүртэл Эзэн Хороог монголчуудын уламжлалт шүтээнийг байрлуулсан шовгор оройтой таван эсгий гэрээс бүрдэж байв. Эхний зүүн талын гэрт Чингис хааны чандарт мөргөхөөр ирсэн хүмүүсийг байлдадаг агаад арын хана нь хоёр дахь гэр рүү орох хаалгатай эхний гэртэй нийлүүлсэн аж. Энэ гэрт Чингис хааны мөнгөн бунхан байв. Гуравдугаарт гэрт Чингис хааны их хатан Бүртэмөлжиний бунхан, дөрөвдүгээр гэрт удаах хатан Хулан хатны бунхан, тавдугаар гэр буюу хамгийн арын гэрт Чингисийн үр удмын бунхантай, монголын хааны шүтээн: мэр сэр зүйлс нь Чингис хаан буюу тэр үеийнх байж мэдэх нум сум, саадаг, эмээл, хазаар, зэр зэвсэг, гэр орны хэрэгсэл байнам. Хатны бунхан хэлбэр хийцээрээ Чингисийнхээс бараг ялгаагүй, тэдгээр нь арай л бага хэмжээтэй юм.


Шовгор хэлбэртэй гэрүүдийн урд нас эдлэгээгий нь бодож өрмөг эдээр хуйлж, олсоор уясан, эсгий бүрээстэй, модон иштэй, хар адууны дэлээр хийсэн Чингис хааны “хар сүлд”-ийг залсан нь өвөрмөц үсэн шүхэр аятай байх. Энэ туг сүлдийг тойруулаад мөн л адууны үсээр хийсэн бас дөрвөн жижиг тугийг залжээ.

Чингисийн шүтээнийг сайн мэддэг дархадууд энэ “хар сүлд” Чингис хааны үеэс хадгалагдаж ирсэн ганц жинхэнэ туг мөн гэдгийг баталж байв. Гэрийн баруун хэсэгт ойролцоогоор 50 м газарт байгаа шөмбөгөр оройтой бас нэг жижиг гэрт Эзэн Хорооны нандин шүтээнийг хамгаалагч дархадууд аж төрдөг байна.

Эзэн Хороон дахь шовгор оройтой гэрүүд өдгөө цагийн монгол гэрээс том нь ч том, “Афганистаны хазааруудын орон гэр болох ханаи хыргаас хавьгүй өндөр их том”⁵ гэж хэлэхээр арай ч биш юм. Гэхдээ Э.Г.Гафферберг хазаарын ханаи хырга Эзэн Хороон дахь гэрүүдтэй тун адил, ханаи хырга XIII зууны эртний монгол гэрийн хөгжил хувьслын хэлбэр гэж үзэж болно гэсэнтэй маргашгүй. Харин монгол гэрийн хэмжээг тэрээр Г.Н.Потанины авсан гэрэл зургаас эндүү тогтоожээ.⁶ Э.Г.Гафферберг “Их Эзэн Хорооны гэрүүдийн харьцааг харахад ханыг хоёр үе давхарлан барьсан гэхээр байна. Энэ нь хоёр гэрийн хооронд сууж буй хүн жижиг харагдаж байгаагаар тодорхойлж болох байна”.⁷ Гэтэл Г.Н.Потанины зураг дээрхи Эзэн Хороон дахь гэрийн дэргэд бага хүүхдийн зургийг авсан байна шүү дээ. Эдгээр гэрийн тотгоны өндөр баргийн хүн тонгойж орохоор байсан.

Улс орноо чөлөөлсний дараа Чингис хааны онгоныг Эзэн Хороонд эргүүлэн авчирсантай холбогдуулан Их-Зуу аймгийн хүн ам Ардын засгийн газартаа XIII зууны эхэн үеийн монголын феодалын улсыг үндэслэн байгуулагчийн дурсгалд зориулан шинээр сүм байгуулах тухай өргөдөл хүсэлт гаргажээ. ӨМӨЗО-ы Ардын Хороо ард түмний хүсэлтийг талархан хүлээн авч, Чингис хааны сүрлэг, цог жавхлантай сүм-музейн байгууламжинд үлэмж хөрөнгө мөнгө төсөвлөсөн байна.

1955 оны 5-р сард Эзэн Хороонд эртний шовгор оройтой гэрүүдийн ойролцоо шинэ сүмийн барилгын ажлыг эхлүүлжээ. Барилга байгууламж болон сүмийн засварын ажилд хятадын шилдэг барилгачид, архитекторууд, зураачид оролцсон байна. Сүм хийд 2400 ам.дөр.м талбай эзлэх ба өндөр нь 25 м, хятадын орчин үеийн уран барилгын загвараар, монголын уран барилгын элементийг ашиглан “ганжиртай” бөмбөгөр оройтой, шүтээн тахилгын дурсгалыг сүмд агуулсан гэрийн хэлбэртэй байх ажээ.

1956 оны 4-р сарын 8 гэхэд барилга байгууламжийн гол хэсгийн барилгын ажил дуусч, сүмийн доторхи засварын ажил ид өрнөж байв. Хажуугийн хоёр жигүүрийн баруун зүүн талд “их тайлгын” үед хийх баяр ёслолын ажиллагаанд зориулсан гол төв байрны ард мөн тийм жигүүртэй. Сүмийн арын жигүүрт Чингис хааны онгоныг байрлуулж, хажуугийн жигүүрүүдэд түүний хатны бунхан болон Чингис хааны үеийн бусад дурсгалын зүйлс шүтээнийг үзмэр болгож тавихаар төлөвлөжээ. Барилгын дээвэр дээр байрлуулсан дугуй самбарт “” /Чингис хааны онгон/ хэмээн сийлжээ.

Сүмийн урд ойролцоогоор 30 м зайд 16 м-ийн өндөртэй модон хоёр багана байрлуулсныг дархадууд надад тайлбарлахдаа, нэгд нь Чингис хааны “хар сүлд”, харин нөгөөд нь XVII зууны эхээр монголчуудыг нэгтгэж нэгэн улс болгохоор тэмцэж байсан монголын сүүлчийн хаан /Лигдэн хааны “алаг сүлд”-ийг байрлуулна гэсэн юм. Харин монголын эрдэмтэн, профессор Ринчиний мэдээлснээр, 1956 оны намар Эзэн Хороонд очиход нь дээрхи тугийг сүмийн дотор байрлуулсан байжээ.

Сүм-музейн эргэн тойронд жимсний модны цэцэрлэг байгуулж, хашаа хороо босгож, дуганаас холгүй зочидын тохилог буудал барьсан байв. Эзэн Хорооны дурсгалт газрыг үзэх миний аялал үүгээр дууссан юм.

4-р сарын 9-ний өглөө намайг Ма Фуган, Цзин Ханвэн болон бусад бараа бологсдын хамт Дуншэнь хотод ирэхэд Их-Зуу аймгийн Ардын Хорооны дарга, Ордост гарсан хувьсгалт хөдөлгөөнд оролцогч Ван Юэфын (Арвинбаяр) биднийг найрсгаар хүлээн авсан билээ.

1956 оны 6-р сарын 12-ноос Чингис хааны дурсгалын шинэ сүм-музей нээгдэж, шүтээн тахилга, онгон бүгдийг тэнд тахин залжээ.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Ц.Жамцарано, Поездка в Южную Монголию в 1909-1910 гг., “Известия Русского комитета для изучения Средней и Восточной Азии”, серия 11, №2, СПб., 1913, стр. 46, сноска 2.
2. Там же, стр. 47
3. Б.Я.Владимирцов, Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм, Л., 1934, стр. 18
4. Ц.Жамцарано, Поездка ..., стр.48
5. Э.Г.Гафферберг, Хазарейская юрта ханаи хырга (к вопросу об истории кочевого жилища), “Сб. Музея антропологии и этнографии”, т. XIV, 1953, стр. 91
6. Г.Н.Потанин, Поминки по Чингис-хане, “Известия русского географического общества”, т. XXI, 1885
7. Э.Г.Гафферберг, Хазарейская юрта..., стр. 91

*“Филология и история монгольских народов” Москва, 1958
номонд орсон өгуулэл, хавсралт. (стр.228-276)*

*Орос хэлнээс орчуулсан Ч.Батцэцэг /ОУСХ-ийн эрдэм
шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)/*